



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2024/40/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Ховд хот 2024 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 99047408 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас: 99013699 Цахим хаяг: tsetsegsurena@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Нарантуул Утас: 99019800 Цахим хаяг: narantuuld@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2024-02-09 № 1/25
танай 2024-01-24 -ны № 04 -Т

ХОВД СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Х.ЖЕМИСГҮЛ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Ховд сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, бараа материалын тайлан гаргалт хангалтгүй, эм эмнэлгийн хэрэгслийн санхүүгийн программ дахь үлдэгдэл, тооллогын үлдэгдэл зөрүүтэй, Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталсан 1 өвчтөнд зарцуулах мах махан бүтээгдэхүүний норм норматив мөрдөөгүй, Шилэн дансны тухай хуульд заасан дараа жилийн төсвийн төсөл, хагас жилийн санхүүгийн тайлан баланс, зарлагын ажил гүйлгээг мэдээлээгүй зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Сангийн сайдын 2017 оны 347 дүгээр тушаалын НХМаягт БМ-9-д "бараа материалын тайланг нярав, эд хариуцагч нь аж ахуйн нэгж байгууллагын бүртгэлийн бодлогын баримт бичигт заасан хугацаанд агуулахын бүртгэлд үндэслэн материалын нэр төрөл тус бүрийн тоо хэмжээгээр нэгтгэн гаргана. Бараа материалын тайланг нярав, эд хариуцагч нар дээр хөтлөгдөж буй агуулахын бүртгэлтэй тулган шалган хүлээж авна", ЭМС-ийн А/74 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтад заасантай заалтуудтай тус тус нийцээгүй, "Тохиолдсон байх", "Иж бүрэн байх", "Нийцсэн бөгөөд зохистой байх", "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2023 оны 04,05,06,07,08 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээ, оношийн хамааралтай бүлгийн жагсаалт, төлбөрийн хэмжээ, санхүүжүүлэх төлбөрийн арга, багц, төлбөрийн хэмжээ, тусламж үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах зэрэг журмыг шинэчлэн баталсан байна.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Ховд сумын Эрүүл мэндийн төв нь эрүүл мэндийн даатгалын сангаас иргэдэд үзүүлсэн эмнэлгийн тусламж үйлчилгээний санхүүжилтээр 534.1 сая төгрөгийг авч, 19.7 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу авч авлагаар бүртгэсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Ховд сумын Эрүүл мэндийн төв нь тайлант онд 7 зорилтын хүрээнд 51 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, биелэлтийг дүгнүүлээгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>43,977,389.48</u>	<u>79,537,206.77</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	21,031,131.07	30,601,798.97
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	21,031,131.07	30,601,798.97
3121	Төгрөг	21,031,131.07	30,601,798.97
31211	Төрийн сангийн харилцах	21,031,131.07	30,601,798.97
33	АВЛАГА	792,900.51	20,170,490.24
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	263,279.51	128,229.24
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	19,743,913.00
335	Бусад авлага	529,621.00	298,348.00
3351	Байгууллагаас авах авлага	231,273.00	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	298,348.00	298,348.00
34	УРЬДЧИЛГАА	3,960,000.00	-
3471	Урьдчилгаа тооцоо	3,960,000.00	-
34713	Цалингийн урьдчилгаа	3,960,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	18,193,357.90	28,764,917.56
351	Түүхий эд материал	1,379,977.00	11,534,278.64
35130	Эм боох материал	1,379,977.00	11,534,278.64
354	Хангамжийн материал	16,813,380.90	17,230,638.92
35410	Бичиг хэргийн материал	573,300.00	430,300.00
35420	Аж ахуйн материал	10,322,581.00	9,999,185.02
35460	Хүнсний материал	1,509,999.90	1,542,699.90
35470	Бусад хангамжийн материал	4,407,500.00	5,258,454.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>374,254,011.03</u>	<u>390,819,338.72</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	374,254,011.03	390,819,338.72
392	Биет хөрөнгө	361,880,275.65	378,502,728.38
39201	Барилга, байгууламж, орон сууц	298,000,440.62	298,000,440.62
39202	Хуримтлагдсан элэгдэл	(36,906,693.96)	(48,217,059.60)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	65,550,220.00	65,550,220.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(17,008,615.51)	(31,736,670.55)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	121,864,955.12	186,238,290.62
39206	Хуримтлагдсан элэгдэл	(73,690,306.72)	(94,530,803.81)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	21,231,040.00	21,231,040.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(17,160,763.90)	(18,032,728.90)
393	Биет бус хөрөнгө	12,373,735.38	12,316,610.34
39301	Программ хангамж	982,000.00	982,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(706,864.62)	(763,989.66)
39303	Бусад биет бус хөрөнгө	12,098,600.00	12,098,600.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>418,231,400.51</u>	<u>470,356,545.49</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>10,992,925.00</u>	<u>9,854,355.15</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	10,992,925.00	9,854,355.15
413	Өглөг	10,992,925.00	9,854,355.15
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	3,893,361.42

41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	10,890,180.00	5,960,993.73
41330	Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг	102,745.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	407,238,475.51	460,502,190.34
51	Засгийн газрын хувь оролцоо	407,238,475.51	460,502,190.34
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	160,773,037.00	160,773,037.00
51101	Өмч: - төрийн	160,773,037.00	160,773,037.00
512	Хуримтлагдсан үр дүн	124,146,557.07	177,410,271.90
51210	Өмнөх үеийн үр дүн	124,146,557.07	120,186,557.07
51220	Тайлант үеийн үр дүн	-	57,223,714.83
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	122,318,881.44	122,318,881.44
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	418,231,400.51	470,356,545.49

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	624,427,678.36	671,580,518.04
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	102,812,688.36	79,105,237.41
120	Нийтлэг татварын бус орлого	102,812,688.36	79,105,237.41
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	102,812,688.36	79,105,237.41
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	102,812,688.36	79,105,237.41
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	521,614,990.00	592,475,280.63
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	380,000.00	20,535,913.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	380,000.00	792,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	19,743,913.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	24,810,000.00	37,786,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	24,810,000.00	37,786,400.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	496,424,990.00	534,152,967.63
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	75,297.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	496,424,990.00	534,077,670.63
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	582,656,262.36	614,356,803.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	582,656,262.36	614,356,803.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	582,656,262.36	614,156,803.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	356,679,112.00	371,881,220.00
210101	Үндсэн цалин	219,785,503.00	246,992,007.00
210102	Нэмэгдэл	102,887,110.00	86,649,359.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,255,000.00	4,799,000.00
210104	Урамшуулал	28,751,499.00	33,440,854.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,423,912.56	48,692,542.42
210201	Тэтгэврийн даатгал	31,225,186.72	33,875,865.50
210202	Тэтгэмжийн даатгал	3,549,681.46	3,704,169.23
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,839,745.18	2,963,335.38
210204	Ажилгүйдлийн даатгал	709,936.28	740,833.85

210205	Эрүүл мэндийн даатгал	7,099,362.92	7,408,338.46
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,392,949.00	30,785,213.73
210301	Гэрэл, цахилгаан	1,141,269.00	1,744,733.73
210302	Түлш, халаалт	18,251,680.00	29,040,480.00
2104	Хангамж, бараа материалын зардал	40,701,502.93	39,683,873.98
210401	Бичиг хэрэг	3,958,925.00	8,101,255.00
210402	Тээвэр, шатахуун	26,642,750.00	19,345,073.00
210403	Шуудан, холбоо, интернэгийн төлбөр	1,471,000.00	1,551,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,628,827.93	10,679,045.98
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	7,500.00
2105	Нормативт зардал	76,783,952.80	66,338,185.27
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	69,604,322.80	56,017,735.27
210502	Хоол, хүнс	7,179,630.00	10,320,450.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,080,000.00	-
210604	Урсгал засвар	1,080,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	810,700.00	1,226,000.00
210702	Дотоод албан томилолт	810,700.00	1,226,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	983,000.00	1,565,660.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	1,242,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	209,500.00	143,660.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	773,500.00	180,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40,801,133.07	53,984,107.81
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,979,700.00	6,176,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	35,821,433.07	47,808,007.81
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	200,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	200,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	41,771,416.00	57,223,714.83
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	33.28	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	33.28	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(33.28)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	41,771,382.72	57,223,714.83

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	160,773,037	122,318,881.44	83,798,733.25	366,890,651.69
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(1,423,558.90)	(1,423,558.90)
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	160,773,037	122,318,881.44	82,375,174.35	365,467,092.79
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	41,771,382.72	41,771,382.72

C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	160,773,037	122,318,881.44	124,146,557.07	407,238,475.51
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	160,773,037	122,318,881.44	124,146,557.07	407,238,475.51
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(3,960,000.00)	(3,960,000.00)
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	160,773,037	122,318,881.44	120,186,557.07	403,278,475.51
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	57,223,714.83	57,223,714.83
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	160,773,037	122,318,881.44	177,410,271.90	460,502,190.34

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	549,678,490.00	572,731,367.63
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	549,678,490.00	572,731,367.63
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	380,000.00	792,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	380,000.00	792,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	24,810,000.00	37,786,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	24,810,000.00	37,786,400.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	524,488,490.00	534,152,967.63
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	75,297.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	524,488,490.00	534,077,670.63
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	531,034,770.09	563,160,699.73
21	УРСГАЛ ЗАРДАЛ	531,034,770.09	563,160,699.73
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	531,034,770.09	562,960,699.73
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	362,191,566.09	356,891,695.73
210101	Үндсэн цалин	202,172,555.08	218,118,116.80
210102	Нэмэгдэл	130,867,347.01	82,456,559.45
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,676,000.00	4,806,044.06
210104	Урамшуулал	23,475,664.00	51,510,975.42
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,523,600.00	58,367,400.00
210201	Тэтгэврийн даатгал	31,132,000.00	39,955,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,339,200.00	4,310,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,686,800.00	3,760,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	669,700.00	939,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,695,900.00	9,401,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,384,900.00	37,786,400.00
210301	Гэрэл, цахилгаан	2,123,400.00	1,744,733.73
210302	Түлш, халаалт	12,144,000.00	36,041,666.27
210303	Цэвэр, бохир ус	117,500.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	34,106,300.00	30,326,750.00
210401	Бичиг хэрэг	4,030,650.00	3,779,300.00
210402	Тээвэр, шатахуун	24,993,900.00	19,113,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,471,000.00	1,551,000.00

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,026,250.00	3,682,650.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	584,500.00	2,200,000.00
2105	Нормативт зардал	57,955,954.00	59,823,659.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	50,913,854.00	47,694,109.00
210502	Хоол, хүнс	5,492,000.00	10,079,550.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,550,100.00	2,050,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,813,700.00	4,213,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,400,900.00	4,213,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	790,800.00	-
210604	Урсгал засвар	1,622,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	810,700.00	1,226,000.00
210702	Дотоод албан томилолт	810,700.00	1,226,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,069,000.00	3,105,660.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,000,000.00	2,782,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	-
210803	Даатгалын үйлчилгээ	209,500.00	143,660.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	859,500.00	180,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,179,050.00	11,220,135.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,179,050.00	11,220,135.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	200,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	200,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>18,643,719.91</u>	<u>9,570,667.90</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	18,643,719.91	9,570,667.90
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		21,031,131.07
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	21,031,131.07	30,601,798.97

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	742,778,900	563,160,699.73
21	УРСГАЛ ЗАРДАЛ	742,778,900	563,160,699.73
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	741,778,900	562,960,699.73
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	470,061,200	356,891,695.73
210101	Үндсэн цалин	287,608,200	231,129,092.22
210102	Нэмэгдэл	138,617,000	83,456,559.45
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,336,000	4,806,044.06
210104	Урамшуулал	37,500,000	37,500,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	58,757,600	58,367,400.00
210201	Тэтгэврийн даатгал	39,955,400	39,955,400.00

210202	Тэтгэмжийн даатгал	4,700,200	4,310,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,760,800	3,760,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	939,700	939,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,401,500	9,401,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,786,400	37,786,400.00
210301	Гэрэл, цахилгаан	1,760,400	1,744,733.73
210302	Түлш, халаалт	36,026,000	36,041,666.27
2104	Хангамж, бараа материалын зардал	41,154,600	30,326,750.00
210401	Бичиг хэрэг	6,250,300	3,779,300.00
210402	Тээвэр, шатахуун	24,153,700	19,113,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,250,000	1,551,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,750,300	3,682,650.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,750,300	2,200,000.00
2105	Нормативт зардал	80,951,700	59,823,659.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	65,152,000	47,694,109.00
210502	Хоол, хүнс	10,299,700	10,079,550.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,500,000	2,050,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,000,000	4,213,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,000,000	4,213,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,000,000	
2107	Томилолт, зочны зардал	2,300,000	1,226,000.00
210702	Дотоод албан томилолт	2,300,000	1,226,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,655,000	3,105,660.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,000,000	2,782,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000	-
210803	Даатгалын үйлчилгээ	300,000	143,660.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	80,000	-
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	25,000	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	300,000	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	500,000	180,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,112,400	11,220,135.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,112,400	11,220,135.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,000,000	200,000
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000	200,000
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000	200,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	742,778,900	572,731,367.63
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	792,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		792,000.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	37,786,400.00	37,786,400.00
132001	Орон нутгийн төсвөөс	37,786,400.00	37,786,400.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	704,992,500	534,152,967.63

134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		75,297.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	704,992,500	534,077,670.63
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		21,031,131.07
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		30,601,798.97
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	27	27
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	17	17
620003	Үйлчлэх ажилтан	5	5
620004	Гэрээт ажилтан	4	4
64	ЭМЧЛҮҮЛЭГСДИЙН ТОО	6,376	6,376
640001	Улсын эмнэлгээр хэвтэн эмчлүүлэгсдийн тоо	219	219
640002	Улсын эмнэлгийн амбулаториор эмчлүүлэгсдийн тоо	6,157	6,157
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	27	27
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	18	18
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5	5
650010	Гэрээт ажилтан	4	4

ГУРАВ . АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ :

Аудитаар нийт 49,167.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 18,882.3 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г залруулж, баталгаажуулав. Үүнд:

- ЭМД-ын сангийн санхүүжилтийн авлагыг 2,246.4 мянган төгрөгөөр дутуу,
- Өмнөх онд үүссэн 3,960.0 мянган төгрөгийн авлагыг хаахдаа цалингийн зардлыг нэмэгдүүлсэн,
- Үнэ төлбөргүйгээр ирсэн бараа материалыг үндсэн хөрөнгөд бүртгэсэн, төсвийн хөрөнгөөр худалдан авсан 3,324.7 мянган төгрөгийн БҮТЭЗ-ийг зарлагадсан,
- Үнэ төлбөргүйгээр шилжүүлэн ирсэн 490.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг илүү,
- Санхүүгийн программд тоног төхөөрөмжийн ашиглах жилийг оруулаагүйгээс тайлант оны элэгдлийн зардлыг 588.1 мянган төгрөгөөр дутуу,
- Түлш халаалт, эм эмнэлгийн хэрэгслийн зардлын өглөгийг 3,287.3 мянган төгрөгөөр дутуу,
- Тайлант үеийн үр дүнг 5,075.8 мянган төгрөгөөр зөрүүтэй тусгасан.

Залруулагдаагүй зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс “их” байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 30,285.4 мянган төгрөгийн 3 зөрчил² илэрснээс, 10,570.4 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах албан шаардлага, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

3.1 Албан шаардлага

1. Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмж бүрэн хэрэгжүүлээгүй, нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрийн сургалтын анхан шатны баримтын бүрдэл дутуу, жолоочийн замын хуудсаар зарцуулаагүй үлдсэн 177.5 литр шатахуун бодитой байгаа эсэх нь тодорхой бус, өвчтөний

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хоол хүнсэнд худалдан авсан үхрийн махыг гарцаар тооцон хэмжиж орлогод аваагүй, ЭМС-ын тушаалаар баталсан 1 өвчтөнд зарцуулах норм нормативаар тооцоход 183 кг махыг илүү зарцуулсан, норм норматив мөрдөөгүй, эд хариуцагчийн тайлаан гаргалт хангалтгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 16.5.1-д “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах;”, 16.5.4-д “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Сангийн сайдын 2017 оны 347 дүгээр тушаалын НХМаягт БМ-9-д “бараа материалын тайланг нярав, эд хариуцагч нь аж ахуйн нэгж байгууллагын бүртгэлийн бодлогын баримт бичигт заасан хугацаанд агуулахын бүртгэлд үндэслэн материалын нэр төрөл тус бүрийн тоо хэмжээгээр нэгтгэн гаргана. Бараа материалын тайланг нярав, эд хариуцагч нар дээр хөтлөгдөж буй агуулахын бүртгэлтэй тулган шалган хүлээж авна”, ЭМС-ийн А/74 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтад заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.2.1 Үндсэн хөрөнгө, бараа материалын тооллоготой холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант оны эцэст үндсэн хөрөнгө болон бараа материалын тооллого хийгээгүй, 2013 онд ашиглалтад орсон мотоциклуудыг ашиглах боломжгүй, бодитоор оршин байхгүй, эм эмнэлгийн хэрэгслийн тооллогоорх үлдэгдэл, санхүүгийн программ дахь үлдэгдэлд байгаа эмийн нэр төрөл тоо хэмжээ хоорондоо зөрүүтэй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-д “Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана.” 2/ түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/;” нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгө, бараа материалын тооллогыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу үр дүнтэй хийх

3.2.2 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил

Илрүүлэлт: Шилэн дансны тухай хуульд заасан дагуу 2023 оны хагас жилийн тайлан баланс, дараа жилийн төсвийн төсөл, 5 сая төгрөгөөс дээш зарлагын 1 ажил гүйлгээг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3-д “дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор;”, 6.1.4-д “жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор;”, 6.1.6-д “төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;” Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль, журамд заасны дагуу мэдээллийг тухай бүрд нь мэдээлж хэвших

Дөрөв. Аудитаар илэрсэн буюу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ мян.төгрөг/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ховд сумын Эрүүл мэндийн төв	7	18,882.3	4	11,197.6	3	7,684.7	7	18,882.3	-	-	-	-
Дүн	7	18,882.3	4	11,197.6	3	7,684.7	7	18,882.3	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ мян.төгрөг/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Ховд сумын Эрүүл мэндийн төв	3	30,285.4			1	10,570.4	2	19715	-	-	-	-
Дүн	3	30,285.4	-	-	1	10,570.4	2	19715	-	-	-	-

ТАВ. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	6	7	8	9
1	ТШЗ	-	1	-	-		1	-	-
НИЙТ			1	-	-		1	-	-